

Анхны чуулган

-The First Church-



152Page

Тайлбарлагч

Есүс загалмай дээр цовдлогдон нас бараад гурав хоногийн дараа дахин амилсан. Тэгээд дахин амилсаны 40 өдрийн дараа тэнгэрт одсон. Есүсийг тэнгэрт одсоны дараа дагалдагч нар нь дээврийн өрөөнд цуглаж залбирдаг. Тэнд Есүсийн дагалдагч нар, Мариа, мөн Есүсийг дагаж байсан эмэгтэйчүүд цугласан байлаа. Тэд ингэж хамтдаа цуглаж нэг сэтгэлээр залбиралд нэгдэж байв. Ингээд арван өдөр өнгөрч байтал Иудейчүүдийн баяр болох Пентокест баяр болов.



153Page

Тайлбарлагч

Энэ өдөр ч бас тэд баяр гэж амралгүйгээр залбирч байлаа. Гэтэл гэнэт тэнгэрээс маш хүчтэй салхины чимээ сонсогдож тэр чимээ дээврийн өрөөг дүүргэв. Мөн гал мэт халуун илч тэдний толгойг бүрхэж тогтов. Есүс энэ дэлхий дээр байхдаа амласан Ариун Сүнс тэдний дээр буусан байв. Ариун Сүнсээр дүүрсэн хүн бүр өөрийн мэдэлгүй өөрсдийн ч мэдэхгүй хэлээр ярьцгаах эхлэв.

Харь хэлээр яригч1

Аригота козаймас, шима масэн.

Харь хэлээр яригч2

Ешү шие шие.

Харь хэлээр яригч3

Ди хэбинд фадор, тэнк юү.

Тайлбарлагч

Гадаа байшинг өнгөрч явсан хүмүүс сонин чимээг сонсоод ихэд гайхав.

Хүн1

Үгүй энэ чинь энд байгаа хүмүүс бүгд Галилынх шүү дээ. Гэтэл яаж хоорондоо, өөр орны хэлээр ярьж байнаа.

Хүн2

Тэд архинд согтсон юм шиг байнаа...



154Page

Тайлбарлагч

Петр

Петр хүмүүст Бурханы үгийг дамжуулж эхлэв.

Есүс тэнгэрт одсоны дараа, Түүний туслах Ариун Сүнс бууж ирсэнээр Бурханы үгийг бүгдийн ойлгож зааж эхлэв. Та бүхнийг бүгдийг аврахын тулд Есүсийг илгээсэн.

Тайлбарлагч

Петрийн сургаалыг сонссон хүмүүс түүнээс ийн асуув.

Олон хүн дундаас1

Тэгвэл бид нар яавал аврагдаж чадах вэ?

Петр

Есүст итгэж, Есүсийн нэрээр усан баталгаа хүртвэл гэмийн уучлалыг авах болно.

Олон хүн дундаас2

Бид Есүст итгэхэд л болох уу?



155Page

Петр

Тайлбарлагч

Тийм тийм

Петрийн хэлсэн үгэнд олон хүн урамшин сэтгэл нь хөдлөв. Тэр өдөр Петрийн хэлсэн үгэнд итгэж усан баталгаа хүртсэн хүний тоо гурван мянга хол давав. Үүнээс хойш дагалдагч нар нь Есүсийн тухай ярих бүрд олон хүн итгэж Бурхан уруу эргэж ирсэн гайхамшигтай зүйлүүд болов.



156Page

Тайлбарлагч

Есүсийн дагалдагч нар, Есүст итгэсэн хүмүүс өдөр бүр сүмд цуглан залбирч Бурханд талархаж байв. Тэгээд тэд өөрсдийн хөрөнгийг зарж ядууст хуваан өгч туслаж байлаа. Хоолоо ч мөн адил хуваан идэж байв. Ариун Сүнс буун ирсэний дараа иймэрхүү зүйлүүд бий болж үүнийг ажиглан харж байсан хүмүүс Есүсийн дагалдагч болон итгэгч хүмүүсийг шагшин магтаж Бурханд итгэж аврагдаж байлаа. Энэ бол анхны чуулганы төрх юм.



157Page